

СЭТГҮҮЛ ЗҮЙН ҮНДСЭН КАТЕГОРИЙН ТУХАЙ АСУУДАЛД

М. Зулькафиль*, Х. Шамахайулы**

* МУИС, НШУС, Сэтгүүл зүйн тэнхмийн эрхлэгч, шинжлэх ухааны доктор, профессор.
** Казахстаны Карагандын их сургууль, доктор.

Түлхүүр үг: олон нийтийн мэдээлэл, сэтгүүл зүйн үндсэн категори, мэдээллийн бүтээгдэхүүн, олон нийтийн ухамсар.

Сэтгүүл зүйн онол, практик, арга зүйд "олон нийтийн мэдээлэл" хэмээх нэр томъёог өргөн хэрэглэдэг бөгөөд үүнийг сэтгүүл зүйн үндсэн категори гэж нэрлэдгийг бид мэднэ. Энэ категорийг нэлээд гүнзгий, шинжлэх ухааны үүднээс ойлгохын тулд нийгмийн амьдралыг тодорхойлдог нийгмийн мэдээлэл хэмээх ойлголтын талаар тодорхой төсөөлөлтэй байх шаардлагатай. Өнөөдөр энэ ойлголтыг хэд хэдэн утгаар хэрэглэдгийн дотор явцуу, өргөн утга бүхий хоёр хандлага нэлээд өргөн дэлгэрсэн байдаг. Явцуу утгаар нь авч үзвэл нийгмийн мэдээлэл гэдэг нь нийгмийн амьдралын талаарх бүх төрлийн мэдээлэл мөн. Түүний гол тусгах объект нь ямагт нийгмийн харилцааны аль нэг тал, аль нэг хэсэг байдаг онцлогтой. Өргөн утгаар нь авч үзвэл нийгмийн мэдээлэл гэдэг нь хүмүүсийн бүтээсэн нийгэмд оршин эргэж буй тэмдэгтүүдийн утга агуулга бүхий нийлбэр юм. Энэ нь үргэлж өргөжин баяжиж, мэдээллийн асар их нөөцийг бий болгодог.

Бүх төрлийн "мэдээлэл тэмдэгтийн болон дохионы шинжийг өөртөө

агуулдаг"¹. Гэхдээ бүгдийг заавал хүн бүтээх албагүй. Тухайлбал, анчин ямар нэгэн амьтны мөрийг хараад дүрс, тэмдэгтүүдийн тусламжтайгаар өөртөө хэрэгтэй чухал мэдээллийг олж авч, чоно болохыг мэдээд агнахаар шийдлээ гэж бодъё. Анчны олж авсан энэ мэдээлэл ямар ч тохиолдолд нийгмийн мэдээлэл биш гэдэг нь ойлгомжтой. Тэгвэл анчин сониноос арван хоёрдугаар сарын 10-наас эхлэн чоно агнахыг зөвшөөрсөн тухай мэдээллийг уншаад бэлтгэлээ хангаж эхэлсэн тохиолдолд тухайн мэдээлэл нийгмийн шинжтэй байгаагийн илэрхийлэл юм. Тодорхой зорилгын үүднээс тусгайлан бэлтгэсэн мэдээллийн бүтээгдэхүүн анчны зан байдалд нөлөөлж байгаагаараа нийгмийн мэдээлэл болж байна гэсэн үг. Үүнээс үзэхэд тэмдэгтүүдийн тусламжтайгаар ямар нэгэн материалд илэрхийлэгдсэн нийгэм дэх бүх төрлийн мэдээний бүтээгдэхүүний нийлбэрийг нийгмийн мэдээлэл гэж нэрлэж болох юм. Энд объектив шинжтэй, материаллаг зүйлийн тусламжтайгаар дамжин олны хүртээл болж буй мэдээллийн бүтээгдэхүүний тухай яригдаж байгааг хэлэх хэрэгтэй.

Нийгэмд маш олон төрлийн хэмжээ хязгааргүй их мэдээллийн бүтээгдэхүүн оршдог бөгөөд тэдний

нийгмийн амьдралд гүйцэтгэх үүрэг, эзлэх байр мөн адилхан олон янз юм. Энэ нь тэдний агуулагдаж буй хэл, нийгэмд үзүүлэх нөлөө, зорилго, чиглэл ч өөр байдагтай холбоотой. Техникийн баримт бичиг, хуулийн эмхэтгэл хоёр хөгжмийн зохиомж, энгийн захидал хоёроос эрс өөр зүйл гэдэг нь ойлгомжтой. Гэхдээ энэ бүхэн нь өргөн утгаараа нийгмийн мэдээлэл мөн. Учир нь тухайн цаг үед амьдарч буй хүмүүсийг хооронд нь холбож байгаа төдийгүй, үе дамжин үргэлжилж буй хүмүүсийн хоорондох харилцаанд ч үйлчилж байдаг. Үнэн хэрэг дээрээ энэ бол "түүхийн янз бүрийн үе шатны онцлогт тохирсон бодит байдлыг тусгаж буй олон талт, хөгжил хөдөлгөөн дундаа оршдог объектив шинжтэй нийгмийн ухамсар"² юм.

Энд бас нэг ёсны зөрчил байгааг ажиглаж болно. Нэг талаар бид янз бүрийн хэлээр дамжин илэрдэг маш олон янзын мэдээллийн бүтээгдэхүүний тухай ярьдаг. Энэ утгаараа авч үзвэл тийм мэдээлэл олон түмэнд хүртээмжтэй бус гэсэн дүгнэлтэд хүрч болно. Нөгөө талаар ийм мэдээлэл тухайн цаг үеийн болон үе үеийн хүмүүсийг хооронд нь холбож өгдгийг онцлон тэмдэглэдэг. Энэ зөрчил бол үзэгдлийг танин мэдэх үйл явцад бус, тэр бодит байдлын өөрт нь оршдог онцлогтой. Гэхдээ энэ зөрчлийг шийдвэрлэх арга хэрэгсэл байгааг хэлэх хэрэгтэй. Учир нь нийгмийн мэдээллийн бүтцэд нийгмийн янз бүрийн хэсэг бүлгийн хооронд оюуны гүүр болж чадахуйц өвөрмөц

давхарга оршдог бөгөөд түүний тусламжтайгаар хүн төрөлхтөн нэгдмэл шинжийг хадгалах боломж олж авдаг. Өөрөөр хэлбэл, хүмүүс амьдралын туршлага, ажил мэргэжил, нийгмийн янз бүрийн байр суурь, угсаа гарал, амьдарч буй цаг үеэс үл шалтгаалан нэг нь нөгөөгөө ойлгох чадвартай болдог. Нийгмийн мэдээллийн энэхүү өвөрмөц хэсгийг олон нийтийн мэдээлэл гэж ойлговол зохино.

“Олон нийтийн” гэсэн үгийг өдөр тутмын практикт нэгж зүйл, хэсэг бүлэг гэсэн ойлголтын эсрэг утгаар хэрэглэдэг нь түгээмэл юм. Зөвхөн өдөр тутмын ердийн практикт бус, шинжлэх ухааны салбарт ч ийм утгаар хэрэглэдэг нь ажиглагддаг. Тухайлбал, “олон

«
*Хүмүүс амьдралын туршлага,
ажил мэргэжил, нийгмийн янз
бүрийн байр суурь, угсаа гарал,
амьдарч буй цаг үеэс үл
шалтгаалан нэг нь нөгөөгөө
ойлгох чадвартай болдог.
Нийгмийн мэдээллийн энэхүү
өвөрмөц хэсгийг олон нийтийн
мэдээлэл гэж ойлговол зохино.*

»

нийтийн соёл” хэмээх шинжлэх ухааны ойлголт нэлээд өргөн дэлгэрч нийг бид мэднэ. Энэ ойлголтыг “өндөр төвшний”, “жинхэнэ” соёлын эсрэг үзэгдлийг илэрхийлэх зорилгоор хэрэглэдгийг харгалзан үзвэл ямар нэг байдлаар сөрөг үнэлэмжийн шинжийг агуулдгийг мэдэрч болно. Хэрэв бид Н.Винерийн залуур зүй, Б.Трентовскийн кибернетикийн онолыг “ашиглан нийгмийг өөрөө өөрийгөө зохицуулах систем”³ гэсэн утгаар авч үзвэл мэдээллийг “олон нийтийн” ба “төрөлжсөн” (тусгай) гэж хуваадаг өөр нэг дихтомия (хоёр хэсэгт хуваах үзэл) нэлээд шинэлэг, цаг үеэ олсон байж болох юм.

Далаад оны үед нийгэмд кибернетик хүчтэй нэвтэрч эхэлсэн

нь эрдэмтэн судлаачдын анхаарлыг ихээхэн татаж, энэ асуудлын эргэн тойронд ширүүн маргаан өрнөсөн билээ. Гэвч хориод жилийн дараа нийгмийг судлах кибернетикийн хандлага мартагдаж эхэлсэн бөгөөд өөр үзэл бодол, хандлага давамгайлах болсон юм. Хэдийгээр өөр хандлага давамгайлах болсон ч нийгмийг кибернетикийн шинжтэй систем гэсэн шинжлэх ухааны үзэл баримтлал, түүний өөрөө өөрийгөө зохицуулах механизмын тухай төсөөлөл устаж үгүй болоогүй гэдгийг тэмдэглэх хэрэгтэй. Ийм үзэл баримтлалыг бидний өгүүлж буй сэдэвтэй холбон тайлбарлавал сонирхолтой, бас үр өгөөжтэй болох талтай юм.

Өөрөө өөрийгөө удирдах нарийн төвөгтэй системийн тухай шинжлэх ухаан болох кибернетикийг үндэслэгч Норберт Винер хүн төрөлхтний нийгэм тийм системд багтдаг гэсэн дүгнэлтийг хийж байжээ. Германы нэрт судлаач Георг Клаус нийгмийн өөрөө өөрийгөө удирдах механизмуудын олон төвшний, тархай бутархай бүтэц яаж бүрэлдэн тогтож, яаж үйлчилдгийг тодорхой үзүүлж, үүнийг "зохицуулалтын сүлжилдсэн дүрс" гэж нэрлэсэн байдаг. Хэрэв бид энэ асуудалд арай гүнзгий орж чадвал маш олон соирхолтой зүйлийг ажиглах болно.

Үүнийг илүү амар хялбар ойлгохын тулд эхлээд өөрийнхөө зан байдлыг удирдах механизмын талаар товч өгүүлье. Бид нэлээд бодож боловсруулсан ба огт бодлогогүй тохиолдлын шинжтэй гэсэн хоёр төрлийн үйлдэл хийдэг. Нэг дэх тохиолдолд байгалиас заяасан мэдрэмж үйлчилж, бидний төлөө байгаль "шийдвэр гаргадаг" учир гүнзгийрүүлэн авч үзэх шаардлаггүй. Хоёр дахь тохиолдолд хийж буй

үйлдэлд ажиглаж болох тодорхой нэг үйл явц нөлөөлдөг бөгөөд энэ нь ойролцоогоор тэр хэмжээний үр дүнд хүргэдэг. Бид хүрээлж буй орчны ямар нэгэн өөрчлөлтийн талаар дохио хүлээн авмагц түүний утга учрыг ойлгож, бидний амьдралд яаж нөлөөлөх талаар тайлбарлахын хичээдэг. Үүнээс шалтгаалан өөрийгөө яаж авч явахыг тодорхойлох болно. Дохиог огт тоохгүй өнгөрөх, ирээдүйд анхааралдаа авах, эсвэл шууд ямар нэгэн алхам хийх г.м. Аль ч тохиолдолд зөвхөн шийдвэр гаргасны дараа л үйлдлээ хийж эхэлнэ. Энэ бол бүх хүнд адилхан үйлчилдэг үйл явц мөн.

Дээр бидний өгүүлсэн үйлдлийн үйл явцыг дараах байдлаар үзүүлж болно. Үүнд: үйл явдлын тухай мэдээлэл хүлээн авах—түүнийг тайлбарлах—үр дагаварын хувилбаруудыг авч үзэх—тусгаж авч болох хувилбаруудыг авч үзэх—хувилбарыг сонгох—үйлдлийн тухай шийдвэр гаргах—үйлдэл хийх. Шийдвэр гаргах явдал бидний хувьд үйлдэл хийх мэдээллийн нэгдмэл команд болох ба цаашид олон микрокомандын цуврал болж хувирдаг учир үйл ажиллагааны тодорхой шалтгаанд үндэслэгдсэн мэдээллийн хөтөлбөрийн үндсийг бүрдүүлдэг онцлогтой юм. Энэ хөтөлбөр үйл явдлын ерөнхий дүр төрх, тайлбар, үнэлэлт, үйлдлийн шаардлагатай загвар зэргийг агуулах болно. Үүнийг бид үзэл бодол гэж нэрлэдэг бөгөөд түүнийг бүрдүүлэхэд хамгийн анхны мэдээллээс гадна хоёр гол хүчин зүйл нөлөөлдөг. *Нэгдүгээрт*, хүний бодит байдлыг түрүүлж тусгаж авах чадвар буюу төсөөлөх сэтгэхүй. *Хоёрдугаарт*, хүний ухамсарт хүлээн авч буй бүх мэдээлэлтэй тохирох бүрэлдэхүүн хэсгүүд байгаа явдал юм. Ийм хэсгүүд хүлээж авч буй бүх

шинэ мэдээллийн ач холбогдлыг тодорхойлох, болж байгаа үйл явдалд өгөх үнэлэлт, дүгнэлтийг боловсруулахад тусалдаг нэг ёсны "эх хэмжүүрийн хайрцаг"-ийг бий болгодог. Тэгвэл ийм "хэмжүүрийн хайрцаг"-ийг юу бүрдүүлэх вэ? гэсэн асуулт тулгарч болно.

Нийгмийн ухамсар өөртөө чанарын хувьд эрс өөр өөр элементүүдийг агуулдаг. Энэхүү гол элементүүдийг судлаачид мэдлэг, хэм хэмжээ, үнэт зүйл гэж ангилсан байдаг. Бидний дээр дурдсан хувь хүний "хэмжүүрийн хайрцаг"-ийг энэ элементүүд янз бүрийн төвшинд байдаг боловч хараахан бүрэн хэмжээнд оршдоггүй. Харин хүн нийгмийн мэдээллийн тодорхой хэсгийг эзэмших явцад төгс бүрэлдэн бий болдог онцлогтой. Энэхүү нийгмийн мэдээллийн хэсгийг бид "олон нийтийн мэдээлэл" гэсэн ойлголтоор илэрхийлж ирсэн түүхтэй юм.

Олон нийтийн мэдээллийн хамгийн гол шинжүүдийн нэг нь олон түмэн амьдралын аль нэг хүрээ, салбар, үе шатанд түүнийг ямар нэг байдлаар ашиглах (түшиглэх) явдал юм. Энэ нь хэдийгээр чухал шинжийн нэг боловч шийдвэрлэх үүрэг гүйцэтгэдэггүй. Учир нь олон нийтийн мэдээллийн үүрэг, зорилгоо биелүүлэх үндэс, шалтгаан болсон гол шинжүүдийг илэрхийлж чадахгүй.

Олон нийтийн мэдээллийн янз бүрийн төрөлжсөн болон тусгай мэдээллээс ялгагдах гол онцлог нь *нийтлэг ач холбогдолтой*, өөрөөр хэлбэл, ямар нэг хэмжээгээр бүх нийтийг хамардагт оршино. Мөн олон нийтийн мэдээлэл харилцааны бүх төрлийн сувгаар тардаг учраас хамгийн *хүртээмжтэй*, бүх нийтийг хамарсан шинжтэй байдаг. Дээрх шинж тэмдгүүдэд тулгуурлан олон нийтийн мэдээллийг дараах байд-

лаар тодорхойлж болно. Олон нийтийн мэдээлэл бол нийгмийн мэдээллийн нийгмийн бүх бүлэг, давхаргад зориулсан тэр хэсэг бөгөөд үүнээс шалтгаалан бүх нийтийг хамарсан, нийтлэг ач холбогдолтой мэдээлэл болдог онцлогтой юм.

Олон нийтийн мэдээлэл хувь хүний ухамсрын томоохон хэсгийн үндэс суурийг бүрдүүлдэг учраас нийгмийн ухамсрын тодорхой хэсгийг тэр хэмжээгээр тэжээж, болно. Хувь хүний ухамсарт оршдог нийгмийн харьцангуй тогтвортой, бүх нийтээр хүлээн зөвшөөрсөн мэдлэг, хэм хэмжээ, үнэт зүйл нь нийгмийн өөрөө өөрийгөө удирдах, зохицуулах чухал суваг болон үйлчилдэг. Энэ бол олон нийтийн ухамсрын үйл ажиллагаа юм. Тэгвэл олон *нийтийн ухамсар* гэдэг бол нийгмийн ухамсрын өөр нэг хувилбар, түүний хэсэг бүлгийн болон төрөлжсөн ухамсрын эсрэг чиглэгдсэн нийтлэг ач холбогдол бүхий давхарга мөн. Үүний үр дүнд олон нийтийн ухамсар хүн төрөлхтний шаардлагатай нэгдмэл шинжийг бий болгож, ойртон нягтрах боломжоор хангадаг. Олон нийтийн ухамсар хэдийгээр нарийн төвөгтэй бүтэц бүрэлдэхүүнтэй боловч нийгэм түүний ачаар хямралын нөхцөлд хэсэг бүлгүүдийн тархай бутархай байдлыг даван туулж, нэгдмэл чанарыг хадгалах чадвартай болдог. Олон нийтийн мэдээлэл хүмүүст бий болсон нөхцөл байдлыг харьцангуй зөв үнэлэхэд тусалдаг. Бие хүний цорын ганц шинж нь өвөрмөц бүх нийтээр хүлээн зөвшөөрсөн үнэт зүйл байдаг явдал бол бие хүнийг хүндэтгэх явдал бол соёл иргэншлийн харилцааны бүх нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ мөн.

Олон нийтийн ухамсрын нийтлэг ач холбогдолтой байх чанар нь

харьцангуй шинжтэй юм. Учир нь түүний бүрэлдэхүүн хэсгүүд хувь хүний ухамсрын бүтцэд салангид, цэвэр байдлаар оршдоггүй. Тэд үндэсний, ангийн, мэргэжлийн зэрэг хэсэг бүлгийн болон төрөлжсөн ухамсрын элементүүдтэй харилцан холбоотой оршдог бөгөөд хүнд шууд бэлэн байдаар заяадаггүй онцлогтой. Ердийн нөхцөлд олон нийтийн ухамсар бүрэлдэн тогтох явдал оюуны нэлээд эрчимтэй эрэл хайгуулын үр дүнд бий болохын хамт хүний нийгэмшлийн илэр-

хийлэл болох бие хүний төлөвших үйл явцын хамт явагдах. Нийгмийн болон хүний онцлог, янз бүрийн хөдөлгөөний нийгмийн хэлбэр зэрэг нь ийм байдлаар илэрдэг. Үүний үр дүнд хүн төрөлхтний үнэт зүйл болох ардчилал, олон ургальч үзэл,

уран бүтээлийн эрэл хайгуул бий болдог. Энэ нь хөдөлгөөний нийгмийн хэлбэрийн төвшинд зөрчлийг шийдвэрлэх арга зам бол хүмүүсийн сонголттой холбоотой, өөрөөр хэлбэл, аливаа нийгмийн ач холбогдол бүхний тохиолдолд шийдвэр гаргах аргын аль нэгийг сонгох шаардлагатай гэдгийг ухамсарлан ойлгох ерөнхий зүй тогтлыг бий болгодог онцлогтой. Тухайн тохиолдолд тийм нийгмийн ач холбогдол бүхий нөхцөл бол нийгмийн өөрөө өөрийгөө удирдах механизмын чухал хэсэг болох шинэ үеийнхний олон нийтийн ухамсрыг төлөвшүүлэх үйл явц юм.

Хүний оюуны эрэл хайгуулын хэлбэрээр оршиж буй сонголт хийх боломж нь тухайн нийгэм дэх олон нийтийн мэдээллийн санд агуулагдаж буй мэдлэг, үнэт зүйл, хэм хэмжээний хувьд олон нийтийн ухамсрын хүрээнээс хамаагүй өргөн, олон төрөлтэй байгаа нөхцөлд л бүрэн хангагдах болно. Тиймээс "хүн төрөлхтөн өөрийнхөө бүхий л түүхийн туршид ертөнцийг танин мэдэх, түүнтэй харилцахад тусалдаг мэдлэг, хүрээлэн буй орчныг тусгаж авахад хэмжүүр болж чадахуйц

тогтвортой үнэт зүйлс, нийгмийн зан байдлын шалгуур болохуйц харилцааны хэвшсэн хэм хэмжээг хуримтлуулдаг"⁴. Үүний хамт мэдээллийн сан үе үеийнхний хувь нэмрийг илэрхийлдэг мэдээллийн шинэ бүтээгдэхүүнээр байнга баяжиж гүнзгийрч байдаг. Энэхүү бүтээг-

«

Хүний оюуны эрэл хайгуулын хэлбэрээр оршиж буй сонголт хийх боломж нь тухайн нийгэм дэх олон нийтийн мэдээллийн санд агуулагдаж буй мэдлэг, үнэт зүйл, хэм хэмжээний хувьд олон нийтийн ухамсрын хүрээнээс хамаагүй өргөн, олон төрөлтэй байгаа нөхцөлд л бүрэн хангагдах болно.

»

дэхүүн нь өрсөлдөж чадахуйц шинэ мэдлэг, үнэт зүйлс, хэм хэмжээний хувилбарыг агуулдаг давуу талтай. Хувь хүмүүсийн хувьд сонголт хийх боломж ийм замаар бий болдог бөгөөд үүний үр дүнд нийгмийн олон нийтийн ухамсар өөрийнхөө залгамж чанарыг хадаглан хөгжихөд шаардлагатай нөхцөл бий болдог байна. Хүний бүтээлч үйл ажиллагааны бүтээгдэхүүн болох үзэл бодлын талаарх асуудалд эргэж орьё. Чухамхүү үзэл бодлоор дамжуулан хүн бодит байдлын хөдөлгөөнд хариу өгөх бөгөөд нийгмийн өөрөө өөрийгөө зохицуулах механизмуудыг ойлгох үйл явц энд явагдах болно.

Бид дээр хүн ямар нэгэн шийдвэрийн үндсэн дээр практик алхам хийдэг, шийдвэр үзэл бодлын үндсэн дээр бүрэлддэг гэдгийг тэмдэглэсэн. Тэгвэл үзэл бодол хүн бүрийн тухайн нөхцөл дэх зан байдлын хөтөлбөрийн үүргийг гүйцэтгэдэг нь тодорхой байна. Харин нийгмийн амьдралын хувьд хувь хүний үзэл бодол ямар ач холбогдолтой вэ? Телевизээр дамжуулж буй УИХ-ын хуралдааныг жишээ болгон авъя. Шийдвэрлэхийг шаардсан чухал асуудлын талаар эрхэм гишүүд өөрсдийн үзэл бодлыг илэрхийлж, маргаж, олон талаас нь шүүн хэлэлцдэг. Үүний үр дүнд нийтлэг байр суурийг тодорхойлж, олонхийн саналаар шийдвэр гаргадаг. Эсвэл нийтлэг байр суурийг тодорхойлж чадаагүй нөхцөлд ямарч шийдвэргүй үлддэг. УИХ-ын чуулганд хувь хүмүүс болон хэсэг, бүлгийн гаргаж ирсэн үзэл бодлын талаар хэлэлцэж, санал солилцох бөгөөд ирээдүйн шийдвэрийн нийтлэг үндсийг олох хүртэл түүнийг дэмжих, үнэлэх, нэгтгэн дүгнэх, ил гаргах, хэрэггүй зүйлийг авч хаях зэрэг үйл явц явагдах болно. Өөрөөр хэлбэл, энэ үйл явц сонголттой салшгүй холбоотой гэсэн үг. Тийм сонголтын үндсийг хувь хүмүүсийн үзэл бодол бүрдүүлдэг.

Нийгмийн ач холбогдолтой томоохон үйл явдал болсон үед түүнд зөвхөн хувь хүн төдийгүй, олон нийт (масс) дасан зохицох шаардлага гарч, үзэл бодлыг харгалзан үзэх хүсэл сонирхол төрдөг. Бие хүн нэр хүндтэй, олны анхаарлын төвд байдаг хүн байх тусмаа нийгмийн хувьд түүний үзэл бодол чухал байдаг. Хувь хүмүүсийн үзэл бодол олны сонорт хүрч, түгээн дэлгэрч, хэлэлцүүлгийн сэдэв болох замаар улам боловсронгуй болж, үүний үр дүнд бүх нийтээр хүлээн зөвшөөрсөн сонголт хийх боломж

бүрдэх болно. Ийм нийтлэг сонголтын судлагдахуун бол бий болсон нөхцөл байдлыг урьдчилан тайлбарлах, түүнд хандах хамгийн оновчтой хувилбар болохын хувьд нэг есны хөтөлбөрийн үүргийг гүйцэтгэдэг. Энэ бол хувь хүний үзэл бодлоос хамт олны, нийтлэг, бүгдээрээ хүлээн зөвшөөрсөн хөтөлбөр буюу олон нийтийн үзэл бодол болдог ороо ялгаатай юм. Үүний үндсэн дээр нийгмийн институтууд практик үйл ажиллагааг зохицуулахад чиглэгдсэн удирдлагын шийдвэр гаргаж болно. Хувь хүний болон хэсэг бүлгийн үзэл бодол бий болох, тарах, хэлэлцэх, эргэцүүлэн тунгаах, хянан үзэх, эсэргүүцэх үйл явц бол нийгмийн үзэл бодол өөрийгөө тодорхойлох жам ёсны үйл явц, үзэгдэл мөн. Энд хоёр зүйлийг харгалзан үзэх нь чухал ач холбогдолтой. *Нэгдүгээрт*, хэсэг, бүлгийн үзэл бодол нийгэм-улс төрийн зорилгоос шалтгаалан нэлээд үзэл сурталжсан шинжтэй байдаг нь түгээмэл юм. *Хоёрдугаарт*, боловсрол, мэдлэгийн янз бүрийн төвшний үзэл бодол хоорондоо өрсөлддөг. Чухал ач холбогдол бүхий санал бодлын хамт тухайн асуудлыг онолын үндсэн дээр боловсруулж гаргаж ирсэн санал бодол ч байдаг. Тэд зөвхөн олон нийтийн ухамсрын тогтсон шалгуурт төдийгүй, тусгай, төрөлжсөн, юуны өмнө шинжлэх ухааны мэдээлэл, баримтад тулгуурласан байдаг онцлогтой. Өгч буй үнэлэмжийн үндэслэл, шалтгаан, нийгмийн бусад гишүүнд нөлөөлөх төвшний хувьд ялгаатай байдаг нь чухам үүнд оршино. Гэхдээ мөн чанарын хувьд мэдээллийн энэ бүтээгдэхүүний хэв маяг нэгдмэл шинжтэй юм. Учир нь хүлээн авч буй мэдээллийг сонгох хувь хүний сонголтын шалгуур, мэдээллийг боловсруулах онцлогийг тусгах

болно. Энэ бүхнээс үзэхэд "олон нийтийн үзэл бодол бол хувь хүмүүсийн болон хэсэг, бүлгүүдийн үзэл бодлын өрсөлдөөний үндсэн дээр нийгмийн ухамсрын бий болгодог мэдээллийн өвөрмөц боловсрол бөгөөд байнга өөрчлөгдөж байдаг нийгмийн хөгжлийн явцад олон нийтийн зан байдлын хөтөлбөрийн үүргийг гүйцэтгэх зорилготой" юм. Тиймээс олон нийтийн үзэл бодлыг тодорхойлох явцад юуны өмнө олон нийтийн ухамсрын хэлийг ашигладаг. Өөрөөр хэлбэл, хүмүүсийн үзэл бодол олон нийтийн ухамсрын хэмжүүрт, эсвэл шинжлэх ухааны баримт, мэдээлэлд тулгуурласнаас үл шалтгаалан олон нийтийн мэдээллийн хувьд түүний онцгой нэг төрөл болох нийтлэлийн эх бичвэрт тусгалаа олдог.

Нийгмийн тогтолцоо ардчиллагдсан шинжтэй байх тусмаа олон нийтийн үзэл бодлыг тодорхойлох үйл явц бүрэн төгс явагдах бөгөөд өөрөө удирдах, зохицуулах механизм улам найдвартай үйлчлэх болно. Нийгмийн зан байдал, ухамсрын харилцаа нь нийгмийг зохицуулах механизмын нэг чухал хэсэг бол өөр нэг чухал харилцаа болох засаглалын институт, олон нийтийн хоорондох харилцаа удирдлагын объект ба субъектын үүргийг гүйцэтгэдэг. Энэхүү засаглалын институт олон нийтийн зан байдалд хүмүүсийн ухамсар болон олон нийтийн мэдээлэлгүйгээр нөлөө үзүүлэх боломжгүй юм. Өөрөөр хэлбэл, Георг Клаусын онцлон тэмдэглэсэн зохицуулалтын нэлээд нарийн төвөгтэй "сүлжээ" бий болдог. Энэ бүхний үндсэн дээр нийгмийн аль ч хүрээ, салбарыг удирдахад олон нийтийн мэдээлэл онцгой чухал үүрэг гүйцэтгэдэг элемент мөн гэсэн дүгнэлт хийж болно. Хүн төрөлхтөн түүхийн бүхий л хугацаанд ууж идэж,

өмсөж зүүж болохгүй, буу зэвсэг, хөдөлмөрийн хэрэгсэл, машин техникийн загвар, математикийн томъёо болгон ашиглаж болохгүй нэг л гайхамшигтай бүтээгдэхүүн бий болгохын төлөө асар их хүч хөдөлмөр, цаг хугацаа зарсан нь тохиолдлын зүйл огт биш юм. Энэхүү ер бусын зүйлийн нөлөөгөөр хүмүүс соёлын агуу их сан хөмрөгийн дотор амьдардаг бөгөөд түүнийг "хүн төрөлхтнийг нэгтгэх хэрэгсэл" гэж нэрлэдэг байна.

Олон нийтийн мэдээллийг хүн төрөлхтний амьдралын янз бүрийн үе шатанд янз бүрийн арга, хэрэгслээр үйлдвэрлэж, тарааж байв. Салангид литерийн тусламжтайгаар хэвлэдэг суурь машины бүтээсэн И.Гутенберг хүртэл, түүний дараах үе, компьютер бүтээх үе хүртэл, орчин үеийн аль алинд ч олон нийтийн мэдээллийн үйлдвэрлэл, түүнийг олны хүртэл болгох үйл явцад асар их өөрчлөлт гарч, гадна талаас нь өнгөцхөн харахад эрс тэс ялгаатай мэт боловч дотоод агуулга, зүй тогтлын хувьд цөөнгүй нийтлэг зүйл байгааг ажиглаж болно.

Үүний хамгийн эхний шинж бол хөдөлмөрийн хуваарилалт явагдаж эхэлсэн тэр үеэс нэлээд тогтвортой нийгмийн институтууд бий болж, олон нийтийн мэдээллийг ургал шинжтэй, зохион байгуулалттай гэсэн хоёр төвшинд үйлдвэрлэж байжээ. Урсгал шинжтэй гэдэг нь хүний генетикийн онцлог, бүтээлч чанар, харилцааны байгалиас заяасан чиг баримжаагаас шалтгаалан олон нийтийн мэдээллийг ямар ч хүн бүтээж болно гэсэн үг. Зохион байгуулалттай гэдэг нь институцийн шинжтэй бөгөөд олон нийтийн мэдээллийг тодорхой нийгмийн институтын хүрээнд мэргэжлийн бүтээлч үйл ажиллагааны тусламжтайгаар

бий болгодог үйл явц юм. Үүний үр дүнд олон нийтийн мэдээллийн хоёр давхарга бий болдог. Нэг дэх нь олон түмэн тохиолдлын шинжтэй үйлдвэрлэж, урсгал шинжтэй тараадаг мэдээлэл мөн. Хоёр дахь нь мэргэжилтнүүдийн бий болгож, тусгай нээлттэй сувгуудаар нийт олон түмэнд тарааж буй мэдээлэл юм. Энэ бол театр, концерт, лекцийн зааланд сонсож, хэвлэл мэдээллийн хэрэгслээс уншиж, номын дэлгүүр, рекламн самбар зэргээс олж авч байгаа бүх төрлийн мэдээлэл мөн.

Олон нийтийн мэдээллийг үйлдвэрлэх, тараах үйл ажиллагааны хоёр дахь онцлог шинж бол мэдээлэл нийгмийн бүх мэдээллийн нэгэн адил хуримтлагдах, хадгалагдах шинжийг агуулж эхэлсэнтэй холбоотой бөгөөд нийгмийн мэдээллийн агуулах болох архив, номын сан, дуу болон дүрс бичлэгийн сан, компьютерийн мэдээллийн сан зэрэгт хадгалагдан үлдэх болжээ. Энэ нь олон нийтийн мэдээллийн алтан санг (фонд) бий болгож, түүнийг ашиглах, олны хүртээл болгох ажлыг нэгдсэн зохион байгуулалттай, тодорхой зарчмын үндсэн дээр явуулахыг шаардах болж, өнөөдөр олон нийтийн мэдээллийг тараах, зохион байгуулах тийм нэгдсэн зарчим, хандлага төлөвшиж байна.

Түүхийн хөгжлийн аль ч үед нийтлэг байсан гурав дахь гол шинж бол нэг талаас олон нийтийн мэдээллийн бүтээгдэхүүний ялгарал, нөгөө талаар, нэгдэн нягтрах

хандлага хүчтэй явагдаж ирсэн явдал юм. Энэ хандлагын үүднээс авч үзвэл эртний Грекийн илтгэх урлаг онцгой анхаарал татах болно. Үүнийг сэтгүүл зүйн зарим судлаач "өвөрмөц нийтлэл" эсвэл түүний өмнөх үзэгдэл гэж үздэг. Эртний уран илтгэгчид нэгэн зэрэг синкретик мэдээллийн бүтээгдэхүүн* буюу амьдралын ямар ч тохиолдлын тухай үгийг үйлдвэрлэгчид, бас түгээгчид байсныг амархан ажиглаж болно. Нийгэмд мэдээллийн тодорхой хэрэгцээ бий болж эхэлсэн цагаас үгийн эх бичвэрүүдийг улс

төрийн, шүүхийн, гүн ухааны гэх зэргээр төрөлжүүлж ялгах болжээ. Үүний үр дүнд мэдээллийн үйлдвэрлэлийн хүрээнд хөдөлмөрийн хуваарилалт явагдахын хамт бүтээлч үйл ажиллагааны зарим төрөл хоорондоо нэгдэн нийлэх үйл явц

«

Үүний үр дүнд олон нийтийн мэдээллийн хоёр давхарга бий болдог. Нэг дэх нь олон түмэн тохиолдлын шинжтэй үйлдвэрлэж, урсгал шинжтэй тараадаг мэдээлэл мөн. Хоёр дахь нь мэргэжилтнүүдийн бий болгож, тусгай нээлттэй сувгуудаар нийт олон түмэнд тарааж буй мэдээлэл юм.

»

эхэлсэн юм. Инженер, дүрслэх урлаг, гар урлаг нэгдэн архитектурыг (уран барилга), дараа нь театр үүссэн нь үүний жишээ мөн. Үүнд нөлөөлсөн гол нэг хүчин зүйл бол мэдээллийн бүтээгдэхүүнийг тараах техникийн боломж буюу янз бүрийн сувгууд бий болсон явдал юм. Энэ нь олон түмэнд зориулсан янз бүрийн мэдээллийг чиглэсэн зорилготой төвлөрүүлэх шинэ боломжийг бүрдүүлжээ.

Бидний дээр дурдсан онцлог шинжүүдийн нийлбэр судлаачдын анхаарлыг зүй ёсоор татах асуудал бөгөөд орчин үеийн олон нийтийн

мэдээллийн үйлдвэрлэл, тараах үйл ажиллагаанд ч тэдний шинж тэмдэг оршиж байгааг тэмдэглэх хэрэгтэй. Орчин үед олон нийтийн мэдээлэл гол гурван хэлбэрээр оршдог байна. *Нээдүгээрт*, нэлээд идэвхгүй буюу нийгэмд материалыг "өөрөө хүлээн авах"-ад зориулагдсан эх бичвэр хэлбэрээр оршдог. Янз бүрийн мэдээллийн санд хадгалагдаж бай-мэдээллийн мэдээллүүд хэрэглэгч, гаа тийм мэдээлүүд хэрэглэгч, хүлээн авагчдад хүргэх мэдээлэл харилцааны нөхцөл бий болохыг хүлээж байдаг. *Хоёрдугаарт*, чөлөөтэй бус боловч харьцангуй идэвхтэй хэлбэр буюу олон нийтийн мэдээллийн эх бичвэр тодорхой нэг бүтэц, зохион байгуулалтанд ороогүй хүмүүсийн хоорондох харилцааны сувгуудаар дамжин эргэлтэнд орж байна. Өөрөөр хэлбэл, мэдээлэл шууд үйлдвэрлэгчдээс энэ сувгуудад орж, тухайн харилцааны нөхцөл байдлаас шалтгаалан тодорхой төвшинд өөрчлөн хувирч хэрэглэгчдэд хүрдэг. *Гуравдугаарт*, чөлөөтэй, хэт идэвхтэй хэлбэр буюу тусгайлан зохион байгуулсан нийгмийн институтууд хүлээн авагчдад олон нийтийн мэдээллийг өгөх явдал юм. Энэ бол тодорхой бүтэц, зохион байгуулалт бүхий мэдээллийн сувгуудаар олон нийтийн мэдээллийг чөлөөтэй, ил тод, хүртээмжтэй, тогтмол өгөх үйл ажиллагаа мөн. Энэхүү "мэдээллийн нийлбэрийг судлаачид "олон нийтийн мэдээллийн урсгал" хэмээх ойлголтын хүрээнд авч үздэг. "Олон нийтийн мэдээлэл-харилцааны суваг" хэмээх ойлголт тодорхойлолтын хувьд үүнтэй нягт холбоотой"⁶ бөгөөд энэ хоёрын хоорондох харилцааг гол мөрөн, түүний сав хоёрын харилцаатай адилтган үзэж болно. Сав нь ном, тогтмол хэвлэл, радио, телевиз, баримтат кино, компьютерийн сүлжээ зэрэг мэдээлэл-харилцааны сувгууд бол гол

мөрөн нь энэ сувгуудаар өгч байгаа агуулга, олон нийтийн мэдээллийн эх бичвэрүүд юм. Энэхүү мэдээллүүдийн нийлбэр нь олон нийтийн мэдээллийн урсгалыг бий болгодог. Ийм мэдээллийн гол хэсгийг тусгай институтуудын бэлтгэсэн орчин үеийн мэдээлэл эзэлдэг боловч шаардлагатай үед урсгалын шинжтэй, тохиолдлын мэдээллийн эх бичвэрүүд ч тодорхой байр эзэлдэг. Олон нийтийн мэдээллийн урсгал гэдгийг олон нийтийн мэдээллийн эх сурвалж, ямар давхаргад хамаарагдахаас үл шалтгаалан оршин тогтнох арга гэж тодорхойлж болно.

Олон нийтийн мэдээллийн янз бүрийн эх бичвэрүүдийг өөртөө төвлөрүүлж, бас түүнийг цаг үеийн шинжтэй болгож буй олон нийтийн мэдээллийн урсгалын тусламжтайгаар нийгэм өөрийнхөө тэргүүн зэргийг хэрэгцээг хангах онцлогтой юм. Энэ нь юуны өмнө дараах хэрэгцээг өөртөө агуулдаг. Үүнд:

- олон нийтийн ухамсар буюу хүлээн авч буй мэдээллийг эзэмшихэд "хэмжүүрийн хайрцаг"-ийн үүргийг гүйцэтгэдэг нийгмийн ухамсрын нэг хувилбарыг төлөвшүүлэх;

- нийгмийн ач холбогдолтой үйл явдал, үзэгдэл, баримт, өөрчлөлтийн талаарх мэдээллийг хүлээн авах, шуурхай тараах;

- олон нийтийн үзэл бодлыг бүрдүүлэх;

- олон нийтийг шаардлагатай практик үйл ажиллагаанд татан оролцуулах зорилгоор нийгмийн институтуудын гаргаж буй удирдлагын шинжтэй шийдвэрүүдийг боловсруулах, тараахад нөлөөлөх;

- нийгмийн практик үйл ажиллагааг эрчимжүүлэхэд нөлөөлдөг олон нийтийн болон хэсэг, бүлгүүдийн сонирхлыг идэвхжүүлэхэд чухал ач холбогдолтой хэсэг

бүлгүүдийн хоорондох харилцааг тодорхой төвшинд дэмжих;

- бий болсон тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэхэд иргэдэд болон бие даасан бүлгүүдэд туслах;

- шаардлагатай үед нийгэмд чухал үйлдэл хийх, шийдвэр гаргах, зан байдлыг өөрчлөхөд бэлэн байдаг олон нийтийн сэтгэл зүйн байдал, хэм хэмжээг мэдрэх, дэмжих зэрэг болно.

Олон нийтийн мэдээллийн урсгалын хувьд бидний дээр дурдсан хэрэгцээ, шаардлагууд түүний үүрэг, зорилгыг болон эх бичвэрүүдийн агуулгыг тодорхойлох үндсэн шалтгаан болдог.

Хэрэв энэ мэдээлэл, эх бичвэрийг зорилго, үүрэг, чиглэлийн хувьд ангилбал хэрэгцээ, шаардлага бүрийн онцлогийг илэрхийлсэн бас л долоон томоохон хэсэгт хуваагддаг. Үүнд:

- Нэгдүгээр хэсэгт олон нийтийн ухамсрыг бүрдүүлэхэд чиглэгдсэн хүмүүсийн оюуны эрэл хайгуулыг дэмжих, нөлөөлөхөд чиглэгдсэн эх бичвэрүүд багтдаг. Энэ хэсгийн хүрээ маш өргөн бөгөөд шинжлэх ухааны ололт, үзэл бодлын болон гоо зүйн үнэт зүйлс, нийгмийн туйлын зорилгыг чиг баримжаа болгосон зан байдлын хэм хэмжээ зэрэг зүйлийг тусгасан материалууд ордог.

- Хоёрдугаар хэсгийн материалууд бодит байдлын өөрчлөлтийг ил (үйл явдал) болон далд (тулгамдсан асуудал) тусгасан байдгаараа онцлогтой. Энэ бол мэдээллийн, асуудал дэвшүүлсэн, задлан шинжилсэн бүх төрлийн нийтлэл юм.

- Гуравдугаар хэсгийг олон түмнийг болж байгаа үйл явдлын болон нийгмийн тулгамдсан асуудлын талаарх янз бүрийн үзэл бодолтой танилцуулах зорилго агуулдаг. Үүнд улс төрчид, эрдэмтэд,

сэтгүүлчид болон бусад хүмүүсийн цаг үеийн чухал асуудлуудыг тусгасан нийтлэлүүд багтдаг.

- Дөрөвдүгээр хэсгийг олон нийтийн өдөр тутмын зан байдлыг удирдахад чиглэгдсэн засаглалын институтуудын шийдвэрүүдийн тухай мэдээллийг агуулсан удирдан чиглүүлэх шинж бүхий эх бичвэрүүд бүрдүүлдэг.

- Тавдугаар хэсгийн материалууд хүлээн авагчдыг янз бүрийн хэсэг бүлгийн үнэт зүйлс буюу ястан үндэстэн, мэргэжлийн, насны, хүйсийн зэрэг нийгмийн янз бүрийн давхаргын үзэл бодлын, соёлын өвөрмөц онцлогтой танилцуулах зорилготой юм.

- Зургадугаар хэсгийн эх бичвэрүүд хүмүүсийн хувийн болон ажил төрлийн асуудлуудыг шийдвэрлэхэд чиглэгдсэн бөгөөд үүнд ашигтай зөвлөгөө, зар сурталчилгаа, лавлах материал, тодруулга, асуулт-хариулт, хуулийн зөвлөгөө зэрэг материалууд багтдаг.

- Долдугаар хэсгийн материалууд зугаацуулах үүргийг биелүүлэх зорилготой юм. Өөрөөр хэлбэл, чөлөөт цагийг зөв өнгөрүүлэх, алжаал тайлах, гоо зүйн таашаал авах, сэтгэл зүйн тус дэмжлэг үзүүлэхэд чиглэгдсэн хөгжөөнт, цэнгээнт нэвтрүүлэг, урлаг, утга зохиол, уран сайхны чиглэлийн бүх бүтээл энэ хэсгийг бүрдүүлдэг.

Энэ бүхнээс үзэхэд олон нийтийн мэдээллийн урсгал нь ямар нэг хэмжээгээр хүн болгонд хэрэгтэй эх бичвэрүүдийг өөртөө агуулдаг бөгөөд хамгийн гол нь тэдний бүх нийлбэр цогц нь нийгэмд хэрэгтэй байдгаараа онцгой ач холбогдолтой юм. Учир нь нийгмийн өөрөө өөрийгөө зохицуулах механизмын хэвийн ажиллагааг болон түүний нэгдмэл шинжийг хангахад онцгой үүрэг гүйцэтгэдэг байна.

1. 1992. Мэдээ. Мэдээлэл. Мэдээлэл зүй (Орч. Ч.Эрдэнэ). УБ. Х. 3.
2. Суханов А. П. 1988. Человек и информация. М. С. 135.
3. Винер Н. 1968. Кибернетика, или управление и связь в животном и машине. М.; Трентовский Б. 1972. Искусство управления народом: философский подход к кибернетике. Варшава номыг үзнэ үү.
4. Кean J. 1991. The Media and Democracy. L. P. 36.
5. Лазутина В. Г. 2004. Основы творческой деятельности журналиста. М. С. 34.
6. Терин В. П. Основные направления исследований теории массовой коммуникации //Социологические исследования. 1997. №11. С. 43.

Ашигласан бүтээлийн жагсаалт

1. Винер Н. 1968. Кибернетика, или управление и связь в животном и машине. М.
2. Кean J. 1991. The Media and Democracy. L.
3. Лазутина В. Г. 2004. Основы творческой деятельности журналиста. М.
4. 1992. Мэдээ. Мэдээлэл. Мэдээлэл зүй (Орч. Ч.Эрдэнэ). УБ.
5. Суханов А. П. 1988. Человек и информация. М.

6. Терин В. П. Основные направления исследований теории массовой коммуникации //Социологические исследования. 1997. №11.
7. Трентовский Б. 1972. Искусство управления народом: философский подход к кибернетике. Варшава.

Резюме

Статья посвящена основной категории журналистики — понятию массовой информации. Автор, опираясь на разные теоретические и методологические выводы, мнения исследователей, журналистов и практические примеры, раскрывает сущность понятия "массовая информация" и исследует логическую связь между массовой информацией и другими ключевыми понятиями журналистики, как социальная информация, массовое сознание, общественное мнение, массовые информационные потоки, общественные потребности. Также в статье дается определение понятия "массовая информация", основные ее признаки, формы существования, черты производства и распространения. Автор в статье классифицирует массовые информации по назначению, функциональной направленности на основе их соотношения с потребностями аудитории.